

ТҮР СААТУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

THEORETICAL AND PRACTICAL ISSUES OF TEMPORARY DETENTION



Хууль сахиулахуй

**Т.БАЯРСАЙХАН**

Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Хамгаалалтын газрын Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн Хуяглан хүргэх, албадан ирүүлэх тасгийн дарга, цагдаагийн хошууч, Хууль сахиулахын их сургуулийн магистрант

BAYARSAIKHAN T.

(M.L.Student & Police Major) Head of the Armored Transportation and Judicial Security Unit of the Public Safety Division at the National Police Agency of Mongolia

Товч агуулга: Энэхүү өгүүллээр цагдаагийн эрх бүхий алба хаагчаас гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдсэн хүний нэр, хаягийг тодруулах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор түр саатуулах арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, онол, практикийн зөрчилдөөнтэй асуудлын талаар авч үзсэн.

Abstract: This article explores the theoretical and practical issues related to the temporary detention of criminal suspects, the legal grounds for making such decisions and the regulations that regulate such procedures.

Түлхүүр үгс: Хууль, дүрэм, бичиг баримт, түр саатуулах ажиллагаа, зөрчил, албадан саатуулах, түр саатуулах байр.

Keywords: Law, regulation, document, temporary detention, violation, forcible arrest, detention center.

Цагдаагийн эрх бүхий алба хаагчаас гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдсэн хүний нэр, хаягийг тодруулах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоохын тулд явуулдаг түр саатуулах ажиллагааг явуулахад зөрчилдөөнтэй асуудлууд байна.

Энэ сэдэв нь онол, практикийн түвшинд тодорхой хэмжээгээр судлагдсан хэдий ч өнөөгийн нийгмийн эрэлт хэрэгцээг даган дахин судлах, боловсронгуй болгох хүлээлтийг бий болгосоор байгаа юм.

Түр саатуулах үйл ажиллагааны чиглэлээр тухайлсан судалсан ном бүтээл байхгүй хэдий ч эрдэмтэн судлаачид өөрийн бүтээлдээ хэсэгчилсэн байдлаар тусган авч үзсэн байдаг. Доктор (Sc.D) Ж.Долгорсүрэн “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын захиргааны үйл ажиллагаа”, “Монголын цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны онол, практикийн үндсэн

асуудал”, “Монгол Улсын цагдаагийн эрх зүй” цуврал, “Захиргааны албадлага”, “Монгол Улсын захиргааны эрх зүй ба захиргааны процессын ажиллагаа”, судлаач Д.Булган нарын “Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс”; доктор (Ph.D) Д.Таванжин “Цагдаагийн эрх зүй” сурах бичиг, доктор (Ph.D) Б.Пүрэвийн “Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар”, Т.Батсүх “Цагдан сэргийлэхийн сэргийлэн хамгаалах алба”, Н.Баярмагнай “Эрүүлжүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал” зэргийг нэрлэж болно.

Хүний нийгэм үүсэн бий болсон цагаас эхлэн тухайн нийгмийн гишүүд, хэсэг, бүлэглэлүүд өөр өөрийн гэсэн эд баялгийг эзэмших, түүнийг олж авах, захиран зарцуулах эрх мэдлийн төлөө тэмцсээр иржээ.

Эдгээр баялгуудаас хамгийн үнэтэй нь болох хүний өөрийн эдлэх эрх, эрх чөлөө бөгөөд түүнийг эдлүүлэх, хамгаалах нь хамгийн хариуцлагатай бас маргаантай асуудлуудын нэг байсаар байна.

Хүний эрх, эрх чөлөөг аливаа улс орон бүр өөр, өөрийн зан заншил, шашин шүтлэг, ёс суртахуун, уламжлал, онцлогтоо тохируулан үндэсний эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулан хамгаалдаг.

Монгол Улс хөгжил, дэвшлийнхээ түүхэн урт хугацаанд хүний эрх, эрх чөлөөг хангах, түүнийг хамгаалах талаар зан заншил, уламжлалын төдийгүй эрх зүйн хэмжээгээр хамгаалсаар ирсэн билээ.

Энэхүү хамгаалалт нь тухайн нийгмийнхээ салбар бүрт үйлчлэхүйцээр зохицуулагддаг хэдий ч нийгмийн амьдралаас урган гарч буй шинэ шинэ харилцаа, эрэлт хэрэгцээ, шаардлага, онцлогоос хамааран өөрчлөгдөн шинэчлэгдсээр байна.

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй



тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага¹ билээ.

Дээрх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хийгдэг олон төрөлт арга хэмжээнүүдийн нэг нь цагдаагийн байгууллагын саатуулах үйл ажиллагаа бөгөөд хуулийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлах замаар хийддэг албадлагын арга хэмжээ юм.

Албадлага нь аль ч нийгэмд байдгийг хүн төрөлхтний түүх гэрчилнэ. Тэр нь овог аймгаар амьдарч байсан үед овгийн ахлагчийн нэр хүнд, үлгэр жишээнд суурилж байсан бол төр үүссэн үеэс төрийн эрх мэдэлтэй холбогдон тухайн засаглалынхаа шинжийг илэрхийлдэг.

Хууль зүйн үүднээс албадлагыг юуны өмнө төрөөс эрх зүйн дэг журмыг хангах үйл ажиллагааны арга хэмжээ гэж үздэг. Хууль зүйн шинжлэх ухаан ихэвчлэн эрх зүйн зөрчил гарсантай холбоотойгоор төрийн захиран засаглах заалтыг сахин биелүүлэхийг шаардаж хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан актын хүрээнд хэрэглэгдэх эрх зүйн албадлагыг судалдаг.²

Албадлага гэдгийг Я.Цэвэл "албадлага хавчлага"³, Б.Баярсайхан "албан хүчээр гүйцэтгэх үйлийн нэр, албадлагын арга хэмжээ"⁴ хэмээн тайлбарлажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна."⁵ гэж тунхаглан төр засгаас хүний эрх, эрх чөлөөг хуульчлан хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байгаа ч нийгмийн зүй тогтлоос урган гарч буй өнөөгийн шаардлагыг бүрэн хангасан гэж үзэхэд учир дутагдалтай байна.

Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн улмаас хүний эрх, эрх чөлөө байнга зөрчигдсөөр байгаа нь түүнтэй тэмцэх нь төрийн тулгамдсан асуудлуудын нэг юм.

Энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэх өнөөгийн шаардлагыг хангасан хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөндөгдсөн эрхийг нь

сэргээн эдлүүлэх боломжийг бүрдүүлэх нь чухал болоод байна.

Тухайлбал гэмт хэрэг, захиргааны зөрчлийн улмаас түр хугацаагаар саатуулагдан шалгагдаж байгаа зарим этгээдүүдийг үргэлжлүүлэн албадан саатуулах явдал гардаг бөгөөд үүнийг цагдаа, тагнуул, хилийн цэрэг зэрэг төрийн тусгай чиг үүргийн байгууллагууд гүйцэтгэж байгаа бөгөөд энэ нь саатуулагдсан бүхэн буруутай гэсэн үг биш юм.

"Саатуулах байрны үйл ажиллагаанд хяналт тавих, эдгээрийг хэрэгжүүлэх бодлого, арга зүй, үйл ажиллагааны стратеги, стандарт, дүрэм, журам, заавар, зөвлөмжийг боловсруулах, боловсронгуй болгох, биелэлтийг хангах"⁶ нь цагдаагийн байгууллагын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны нэг чиг үүрэг юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт: "халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно, Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй" гэж заасан.

Аливаа улс өөрийн Үндсэн хуульдаа тулгуурлан түүнд нийцүүлэн бусад хууль тогтоомжуудаа боловсруулж, батлан мөрдүүлдэг нь дэлхий нийтийн түгээмэл жишиг хандлага билээ.

Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална."⁷ гэж заасан нь хүний эрхийг хамгаалах чухал заалт юм.

2017 онд шинэчлэгдэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн 5.1-д "Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, үйл ажиллагаа нь тасралтгүй байх, улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална" гэж заасан.

Саатуулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан хэм хэмжээг дотор нь:

¹ Төрийн мэдээлэл. УБ.2013. №29

² Ж.Долгорсүрэн "Захиргааны албадлага" УБ 1999 он. 21 дэх талд

³ Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь" УБ 1966 он. 19 дахь талд

⁴ Б.Баярсайхан "Монгол хэлний тайлбар толь" УБ 2001 он.30 дахь талд

⁵ Төрийн мэдээлэл УБ.1992. №1

⁶ Төрийн мэдээлэл УБ. 2013. №29

⁷ Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл УБ.1992. №1



Хууль сахиулахуй

- Олон улсын гэрээ, конвенц
- Үндэсний хууль тогтоомж гэж ангилна.

Олон улсын гэрээ конвенцээр саатуулах үйл ажиллагаатай холбоотой хэм хэмжээг тогтоохдоо нэн тэргүүнд саатуулагдсан хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс хамгаалах, нөхөн сэргээх зорилгыг агуулсан байдаг.

Эдгээр хэм хэмжээнд “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”,⁸ “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”⁹, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг олон улсын конвенц”¹⁰, “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”¹¹ зэрэг олон улсын эрх зүйн баримт бичгүүд хамаарна.

Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогцод “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон бүх этгээд өөртэйгөө энэрэнгүй харьцах, хүний хувьд заяасан нэр хүндийг хэрэгжүүлэх эрх эдлэх ёстой хэмээгээд хэрцгий хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх гэдэг томъёог биеийн болон сэтгэл зүйн хүчирхийллээс гадна хоригдож буй байрны нөхцөл нь хүний харах, сонсох болон орон зай ба цаг хугацааг баримжаагаар төрөлхийн аливаа мэдрэхүйгээс түр буюу бүрмөсөн хагацахаар байх ёсгүй гэсэн өргөн утгаар ойлгоно”¹² гэж заажээ.

Үндэсний хууль тогтоомж

Цагдаагийн алба хаагчаас аливаа этгээдийг түр саатуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан хууль тогтоомжууд нь Монгол Улсын гол тулгуур хууль болох Үндсэн хуульд нийцүүлэн гаргасан байдаг. Голлох зарим хууль тогтоомжуудын заримаас дурдвал:

- Цагдаагийн албаны тухай хууль
- Захиргааны хариуцлагын тухай хууль
- Эрүүгийн байцаан шийтгэх тухай

хууль

- Захиргааны журмаар түр саатуулах

журам¹³

⁸ НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/111 дүгээр тогтоол

⁹ НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200/A/XXI тогтоол

¹⁰ 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр батлагдаж, 1987 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон

¹¹ НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 43179 дугаар тогтоол

¹² П.Оюунчимэг Хүний эрх ба эрүү шүүлт УБ 2009 он. 19дэх тал

¹³ ЦЕГ-ын даргын 2015 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлагдсан “Захиргааны журмаар түр саатуулах журам” /код-225/

Захиргааны хариуцлагын тухай хуульд “Түр саатуулах” – цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдсэн хүний нэр, хаягийг тодруулах, албадан саатуулах, баривчлах үндэслэл байгаа эсэхийг тогтоохын тулд түр саатуулах байранд эсхүл албан өрөө, шуурхай удирдлагын албаны зэрэг байр эсхүл шаардлагатай тохиолдолд цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр тогтоосон газарт 6 цаг хүртэл хугацаагаар байлгахыг¹⁴ ойлгоно.

Түр саатуулах ажиллагаа нь өөрөө албадлагын шинжтэй арга хэмжээ учир цагдаагийн алба хаагч хэрэглэхдээ хуульд заасан зарчмыг баримталж ажиллана.

Цагдаагийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 22 дугаар зүйлд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлагын талаар тусгайлан оруулсан нь нэг талаараа хүний эрх, эрх чөлөөг хангах, нөгөө талаараа хууль зүйн дагуу хууль сахиулах ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж байгаа явдал юм.

Мөн хуулийн 22.2-д “Цагдаагийн алба хаагч нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл албадлагын арга хэмжээ авсан тохиолдолд арга хэмжээ авах болсон үндэслэл, шалтгааныг тухайн этгээдэд мэдэгдэж, авсан арга хэмжээтэй холбогдон хүн, хуулийн этгээдэд үүсэх эрх, үүрэг, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, өөрийнхөө эсрэг тайлбар, мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгөх үүрэгтэй”, 22.3-д “Цагдаагийн байгууллага, алба хаагч баривчлагдсан, түр саатуулагдсан насанд хүрээгүй этгээдийн гэр бүлийн гишүүн, эсхүл төрөл садны хүнд энэ тухай мэдэгдэх үүрэгтэй”¹⁵ гэж заасан нь цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх үүргийг нарийвчлан зааж өгсөн гэж ойлгож болно.

Түүх сөхөхөд 1993 онд батлагдсан “Цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийн 24 дүгээр зүйл /Хойшлуулшгүй ажиллагаа/-ийн 24.3-д “Түр саатуулах” ажиллагааны эрх зүйн үндэслэлийг тогтоон өгч байсан боловч 2013 оны “Цагдаагийн албаны тухай хууль”-иар процессын зохицуулалттай зүйл, заалтуудыг оруулаагүй хассан.

Энэ нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн гүйцэтгэх хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг “Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль”-аар оруулан зохицуулахаар

¹⁴ Мөн журмын 225.2

¹⁵ Төрийн мэдээлэл. 2017. №8

тооцоолон тусгайлан боловсруулсан боловч уг хууль нь цаг үеийн байдлаас шалтгаалан УИХ-аар хэлэлцэгдэн батлагдаж чадаагүй болсон.

Энэ хугацаанд түр саатуулах үйл ажиллагааг хуулиар бус цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 225/-аар зохицуулж байсан нь эрх зүйн хүчин чадлын хувьд бүрэн төгс бус, хууль зүйн сөрөг үр дагавартай байсан.

Түр саатуулах үйл ажиллагаа нь Захиргааны хариуцлагын тухай болон Цагдаагийн албаны тухай хуулиудаар тус тус зохицуулагдаж байна. Захиргааны хариуцлагын тухай хууль 2017 оны 07 дугаар сарын 01-ээс хүчин төгөлдөр бус болно.

Шинэчлэгдсэн Цагдаагийн албаны тухай хууль нь 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн УИХ-ын чуулганаар батлагдаж, 3 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн билээ.

Уг хуулийн 26.1-д “Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүний нэр, хаягийг тодруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор үүнийг зургаан цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно” гэж заасан нь цагдаагийн алба хаагчийн түр саатуулах үйл ажиллагааны эрх зүйн гол үндэслэл болно.

Мөн хуулийн 26.2-д түр саатуулах хугацааны талаарх зохицуулалт орсон бөгөөд хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцохоор зохицуулжээ.

Харин 26.3-д “Цагдаагийн байгууллага хүнийг түр саатуулснаас хойш гурван цагийн дотор тухайн хүнд гэр бүлийн гишүүн, өмгөөлөгч, ойр дотнын хүндээ байгаа газраа мэдэгдэх боломжоор хангах зорилгоор утсаар нэг удаа яриулна”¹⁶ гэж заасан нь саатуулагдсан хүний эрхээ эдлэх боломжийг олгож байгаа нэг хэлбэр юм.

ЦЕГ-ын даргын 2015 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлагдсан “Захиргааны журмаар түр саатуулах журам” /код 225/-аар түр саатуулах ажиллагаа, байр, уг байранд тухайн этгээдийг хүлээн авах, анхаарах асуудлуудыг нарийвчлан зааж өгсөн. Уг журмын 225.3.1.цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдсэн этгээдийг дор дурдсан үндэслэл тогтоогдсон тохиолдолд маягтын /ЦБҮАЖ №225.31/ дагуу тэмдэглэл үйлдэж түр саатуулж болно: а/нэр, хаягийг тодруулах;

б/албадан саатуулах буюу баривчлах

¹⁶ Төрийн мэдээлэл. 2017. №8

албадлагын арга хэмжээ авах үндэслэл байгаа эсэхийг тогтоохын тулд 6 цаг хүртэл хугацаагаар саатуулж болно.

Дээрх эрх зүйн зохицуулалтаас харахад түр саатуулах байр байхгүй, нас, хүйсийн онцлог байдлыг харгалзсан тусад нь байрлуулах өрөө тасалгаа байхгүй байна.

Эрх зүйн зохицуулалтаас гадна түр саатуулах хугацаатай холбоотой асуудлыг товчхон авч үзье.

Саатуулагдсан иргэнийг заавал саатуулах байранд хүргэсний дараа түр саатуулах хугацаа тоолж эхлэх ч өнөөдөр Улаанбаатар хотын машины хөдөлгөөний нягтрал ихтэй, зам түгжрэлтэй нөхцөл байдал, хүндрэл, эрсдэлийг дагуулж байна.

Хөдөлгөөнт эргүүлийн машинтай алба хаагчид бичиг баримтгүй сэжиг бүхий иргэнийг саатуулах байранд хурдан хүргэх боломжтой байдаг бол явган эргүүлийн алба хаагчид саатуулах байртай цагдаагийн хэлтэс, тасаг, хэсэг рүү хүргэхдээ нийтийн унаагаар, эсхүл явган явж хүргэх тохиолдолд хүргэж өгөх зам маршрут нь хол, ойроос үл хамааран замын түгжрэлд орох, нийтийн унаагаар зорчих, явганаар хүргэж өгөх зэрэг харилцан адилгүй хугацаагаар саатуулах байранд хүргэж өгч байна.

Өөрөөр хэлбэл түр саатуулах байранд хүргэхээс өмнө иргэн маань цагдаагийн алба хаагчийн хяналтад 6 цагаас илүү хугацаагаар байх шаардлага үүсдэг байна.

Дүгнэлт

Цагдаагийн алба хаагчаас хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж буй түр саатуулах ажиллагаанд дараах 3 тулгамдсан асуудал байна гэж үзэж байна. Үүнд:

1. 2013 оны Цагдаагийн албаны тухай хуулиар “түр саатуулах” ажиллагаа эрх зүйн зохицуулалтгүй болсон нь цагдаагийн алба хаагчаас аливаа гэмт хэрэг, зөрчилд сэрдэгдсэн этгээдийн талаарх шаардлагатай асуудлуудыг тодруулах, цаашлаад гомдол мэдээлэл, хэрэг үнэн зөв шийдэгдэх, цагдаагийн алба хаагчаас авах арга хэмжээ түргэн шуурхай байхад хүндрэл, зөрчилдөөн дагуулж байсныг уг хуулийн шинэчилсэн найруулгаар (2017) өөрчилж, эргэн зохицуулалтад оруулж ирсэн нь дээрх тулгамдсан асуудал шийдвэрлэгдэх чухал алхам болсон байна.

2. Түр саатуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь бүрэн хангагдсан гэж үзэж болохоор боловч уг ажиллагааг явуулах зориулалтын түр саатуулах байр цагдаагийн байгууллагад байхгүй байна.

3. Түр саатуулах хугацааг хэтрүүлэх,

хөтлөгдөх баримт бичгийг алдаатай хөтлөх зэрэг дутагдлууд байна. Тиймээс түр саатуулах байрны үйл ажиллагаа, нөхцөлийг зохицуулах журмыг шинэчлэх шаардлагатай байна.

Санал

1. Цагдаагийн байгууллагын түр саатуулах ажиллагааны талаарх “Захиргааны журмаар түр саатуулах журам” (код 225)-д уг байрны нөхцөл, тавих хяналт, насанд хүрээгүй хүний талаар нарийвчилсан зохицуулалт оруулж өөрчлөх;

2. Насанд хүрээгүй хүмүүс, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тусад нь байрлуулах өрөөтэй байхаар уг байрыг байгуулах;

3. Цагдаагийн алба хаагч иргэнийг саатуулах үндэслэлээ хэлж, хяналтдаа авсан үеэс эхлэн түр саатуулах хугацааг тооцох эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомжид тусгаж өгөх нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчим бодитоор хэрэгжих нөхцөл болно гэж үзэж байна.



Хууль сахиулахуй